

ХАРИЛЦАГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 10 -р сарын 23 өдөр

УЛААНБААТАР хот

Энэхүү “Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид үндэслэн, нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага Тойруу 12, Жуулчны гудамж 7, Худалдаа, хөгжлийн банкны төв байр хаягт орших “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК (цаашид “Компани” гэх), нөгөө талаас хаягт байрлах (хуулийн этгээдийн хувьд РД:, УБД:), түүнийг төлөөлж албан тшаалтай овогтой (цаашид “Харилцагч”, хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээгээр Компани нь Харилцагчийн хүсэлтийн дагуу Харилцагчийг Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгэх, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид “ҮЦТХТ” гэх)-ийн төвлөрсөн хадгаламж, Кастодиан банкны Харилцагчийн үнэт цаасны дансыг нээх, Харилцагчийн үнэт цаасны арилжаанд оролцох захиалга, түүнтэй холбоотой бусад даалгаврыг биелүүлэх, үнэт цаасны дансны гүйлгээтэй холбогдох харилцаанд Харилцагчийн өмнө ҮЦТХТ-ийг, ҮЦТХТ болон Компанитай гэрээт Кастодиан банкны өмнө Харилцагчийг тус тус төлөөлөх, Харилцагч нь Гэрээний дагуу Компанийн үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээг авах, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамж, хөлсийг Компанид төлөхтэй холбоотойгоор Талуудын эрх, үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Хуулийн этгээдийн хувьд тус гэрээний дагуу үүсэх харилцаанд холбогдох хуулийн дагуу Харилцагчийн эрх барих байгууллагаас хуульд заасан шийдвэр гарч, тухайн этгээдэд харилцагчийг албан ёсоор төлөөлөх, түүний хөрөнгийг захиран зарцуулах эрх олгосон хууль ёсны шийдвэрээр баталгаажсан этгээд нь Харилцагчийн бүрэн төлөөлөн Компанитай харилцах бөгөөд Харилцагч болон түүнээс эрх олгосон этгээдийн хооронд үүссэн аливаа маргаанд Компани ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Хоёр. Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх үндсэн нөхцөл

2.1. Харилцагч Компанитай дараах мэдээлэл, үйлчилгээ авах сувгуудаар дамжуулан харилцана. Үүнд:

- 2.1.1. Компанийн төв байранд;
- 2.1.2. Компанийн утасны дугаараар (70100263,70100261,311914);
- 2.1.3. Компанийн цахим шуудангийн хаягаар (info@tdbcapital.mn);
- 2.1.4. Компанийн www.tdbcapital.mn цахим хуудсаар;
- 2.1.5. Харилцагчтай зайнаас холбогдох боломж бүхий компанийн зөвшөөрөгдсөн бусад хэрэгслүүдээр.

2.2. Компани нь Харилцагчид дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх)-г Харилцагчийн хүсэлтийн дагуу түүний Компанид өгсөн үнэн, зөв мэдээллийг үндэслэн үзүүлнэ. Үүнд:

- 2.2.1. ҮЦТХТ-ийн төвлөрсөн хадгаламжид харилцагчийн үнэт цаасны дансыг нээлгэх;
- 2.2.2. Кастодиан банкны харилцагчийн үнэт цаасны дансыг нээх;
- 2.2.3. Харилцагчаас ирүүлсэн үнэт цаас худалдах, худалдан авах захиалгатай холбоотой компанийн үйлчилгээг биечлэн эсхүл зайнаас үзүүлэх;
- 2.2.4. Харилцагчаас ирүүлсэн мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой Компанийн үйлчилгээг биечлэн эсхүл зайнаас үзүүлэх;
- 2.2.5. Компанийн утсаар мэдээлэл, лавлагаа авах, зайнаас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгэх;
- 2.2.6. Компаниас шинээр нэвтрүүлж буй бусад бүх төрлийн үйлчилгээ.

2.3. Гэрээний дагуу ямар төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаа болох нь харилцагчийн гэрээг байгуулах үед гаргасан болон цаашид гаргах хүсэлтээр тодорхойлогдоно. Энэхүү хүсэлт нь гэрээний хавсралт болно.

2.4. Гэрээний хавсралтууд нь тус Гэрээний салшгүй нэг хэсэгт тооцогдоно.

2.5. Компани нь Харилцагчид үйлчилгээг үзүүлэхдээ дараах хэлбэрээр Харилцагчийг баталгаажуулна. Үүнд:

- 2.5.1. Компани нь Харилцагчид биечлэн үйлчилгээ үзүүлэх бол Харилцагчийг баталгаажуулах үндсэн мэдээлэл нь Харилцагчийн зураг, баталгаат гарын үсэг, иргэний хүчин төгөлдөр баримт бичиг байна.
- 2.5.2. Харилцагч нь Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зайнаас авах тохиолдолд үйлчилгээнд ашиглагдах нэвтрэх нэр, нууц үг нь Харилцагчийн баталгаат гарын үсэг (тамга, тэмдгийн бардас)-ийн адил хүчин төгөлдөр болохыг, Компанид бүртгэлтэй Харилцагчийн цахим шуудангийн хаяг, утасны дугаар, нууц асуулт, хариулт болон бусад баталгаажуулалтын хэрэгслүүд нь тухайн Харилцагчийг таних арга хэрэгсэл мөн болохыг Талууд үүгээр зөвшөөрч, харилцан тохиролцов.

2.6. Харилцагч нь Гэрээг байгуулах үед мөрдөгдөж байгаа Компанийн үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл (цаашид “ҮШЕН”), бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл (цаашид “БҮН” гэх)-тэй бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн болно. Харилцагч нь цаашид Компанийн үйлчилгээний шимтгэл, хураамжид орох нэмэлт, өөрчлөлтүүдийг түүний www.tdbcapital.mn цахим хуудсаар дамжуулан онлайн үйлчилгээний эрхээр орж танилцах, эсвэл харилцагч өөрийн биеэр компанид ирж танилцахаар харилцан тохиролцов.

2.7. Компани харилцагчид тус Гэрээний 2.6-д заасны дагуу ҮШЕН, БҮН-д нэмэлт, өөрчлөлт орсон эсхүл шинэчлэгдсэн тохиолдолд Харилцагчид тус Гэрээний 2.1-т заасан сувгуудын аль нэгээр дамжуулан мэдээлэл хүргүүлэх бөгөөд ийнхүү мэдээлэл хүргүүлсэнээс хойш хуанлын 14 хоногийн дотор Харилцагч санал, хүсэлт ирүүлээгүй бол Компанийн ҮШЕН, БҮН-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр Талууд харилцан тохиролцов.

2.8. Компани нь тус Гэрээнд заасан үнэт цаасны захиалгын болон мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой үйлчилгээг Харилцагчид зайнаас үзүүлэх буюу онлайн үйлчилгээгээр үзүүлэх тохиолдолд тус үйлчилгээнээс төлбөр авах бөгөөд тус хураамж нь Компанийн ҮШЕН-д тусгасан байна.

2.9. Талууд нь ҮШЕН-ийн нөхцлийг Гэрээний 2.6-д зааснаас өөрөөр тохиролцож болох бөгөөд энэ тохиолдолд Харилцагч нь Компанид бичгээр хүсэлт гаргана.

Гурав. Харилцагчийн нийтлэг эрх үүрэг

3.1. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 3.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Компаниас шаардах;
- 3.1.2. Компанид бичгээр хүсэлт гарган, нотариатаар баталгаажуулсан гэрээслэл, өвлөх эрхийн гэрчилгээ болон итгэмжлэлээр өөрийн өв залгамжлагч болон үнэт цаасны данс ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлох;
- 3.1.3. Үнэт цаасны зах зээлийн талаар болон Компаниас үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл авах;
- 3.1.4. Хүсэлт гарган Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;
- 3.1.5. Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Компанийн цахим сувгуудыг ашиглан захиран зарцуулах, тохиргоо, мэдээллийг бичгээр гаргасан хүсэлтийн дагуу эсхүл цахим сувгуудаар дамжуулан өөрчлөх, шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;
- 3.1.6. Компанитай байгуулах гэрээг хугацаанаас өмнө цуцлах, эсхүл сонгосон үйлчилгээнээс татгалзах;
- 3.1.7. Компанийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан зардал, хохирлыг Компаниар төлүүлэх;
- 3.1.8. Хуульд заасан бусад эрх эдлэх.

3.2. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.2.1. Компанийн цахим хуудсаар дамжуулан Компанийн онлайн үйлчилгээнд нэвтэрч ҮШЕН-д оруулсан нэмэлт, өөрчлөлттэй танилцах;
- 3.2.2. Харилцагч нь Үйлчилгээ авахын өмнө Компаниас шаардсан бичиг баримт, мэдээ мэдээллийг гаргаж өгөх, тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр, албан ёсоор Компани болон ҮЦТХТ-д мэдэгдэх ба үнэн зөв мэдээллээр хангах;

- 3.2.3. Онлайн үйлчилгээний, дансны, арилжааны болон гүйлгээний шимтгэл, хураамж, үйлчилгээний хөлсийг үл маргах журмаар Компанид саадгүй төлөх;
- 3.2.4. Харилцагч нь Компаниар дамжуулан Эрх бүхий байгууллага (“Эрх бүхий байгууллага” гэж үнэт цаасны үйл ажиллагаанд оролцогч зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Арилжааны төлбөр тооцоо ХХК болон бусад хуулиар тогтоосон эрх бүхий байгууллагуудыг ойлгоно.) болон төлбөр гүйцэтгэх банк (Клиринг банк)-ны авах үйлчилгээний шимтгэл, хураамжийг Эрх бүхий байгууллага, Төлбөр гүйцэтгэх банк болон Компаниас тогтоосон нөхцлийн дагуу үл маргалдах журмаар саадгүй төлөх;
- 3.2.5. Үйлчилгээнд нэвтрэх нэр, нууц үг, нууц асуулт, нууц хариулт болон бусад баталгаажуулалтын хэлбэрийг бусдад дамжуулсан, задруулсан, алдсан, нууцлалын төхөөрөмжийг гээсэн, алдсан, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс захиалга өгөх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 3.2.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавар, гарын авлагыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зөрчсөнөөс үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
- 3.2.7. Үйлчилгээнд нэвтрэх нэр, нууц үг, нууц асуулт, нууц хариулт болон бусад баталгаажуулалтын мэдээллийг мартсан, буруу оруулсанаас үнэт цаасны арилжаанд оролцож чадаагүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
- 3.2.8. Үйлчилгээг ашиглах явцад харилцагч нь Гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Компанид болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүсгэсэн, эсхүл үүсэх аливаа хохирол, зардал, асуудлыг бүрэн хариуцах;
- 3.2.9. Компаниас тавьсан шаардлагын дагуу өөрийн гарын үсгийн баталгааг өгөх, цаашид арилжаанд оролцох, гүйлгээ хийхэд тухайн гарын үсгээ ашиглах бөгөөд энэхүү үүргээ зөрчсөнөөс үүдэн гарах хохирлыг харилцагч бүрэн хариуцах;
- 3.2.10. Компанийн ажилтан, албан хаагчидтай хүндэтгэлтэй харьцах, хууль тогтоомжоор зөвшөөрсөн мэдээ, мэдээлэл хүсэх;
- 3.2.11. Компанийн БҮН-ийг хүлээн зөвшөөрөх;
- 3.2.12. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх.

Дөрөв. Компанийн нийтлэг эрх, үүрэг

4.1. Компани дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 4.1.1. УШЕН-д өөрийн санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 4.1.2. Харилцагч Гэрээгээр хүлээсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж, Харилцагчаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг шаардах;
- 4.1.3. Харилцагчийн буруугаас Компани болон аливаа этгээдэд хохирол учирсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах;
- 4.1.4. Хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Харилцагчаас шаардах;
- 4.1.5. Харилцагчийн үйлдэл нь хууль зөрчсөн бол энэ тухай төрийн эрх бүхий байгууллагуудад хуульд заасны дагуу мэдэгдэх;
- 4.1.6. Хууль болон Гэрээнд заасан бусад эрх.

4.2. Компани дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 4.2.1. Харилцагчийн мэдээллийн нууцлалыг хадгалж, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөхгүй байх;
- 4.2.2. Харилцагчид дотоодын үнэт цаасны зах зээлийн талаар болон Компаниас үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл өгөх;
- 4.2.3. Харилцагчийн хүсэлтийн дагуу Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр үзүүлэх, эрхийг сэргээх эсхүл хаах;
- 4.2.4. Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Компанийн цахим сувгуудыг ашиглан авах боломжоор хангах;
- 4.2.5. Компанийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан зардал, хохирлыг бүрэн хариуцах;
- 4.2.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх.

Тав. Маргаан шийдвэрлэх

- 5.1. Гэрээтэй холбогдуулан үүссэн маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 5.2. Хэрэв тус Гэрээний 5.1-д заасан журмаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

Зургаа. Гэрээ цуцлах, дуусгавар болох, данс хаах

6.1. Дараах тохиолдолд Гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Үүнд:

- 6.1.1. Харилцагчийн хүсэлтийг үндэслэж Гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Гэрээг цуцалсанаар харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эзэмших эрхийг цуцалж, данс болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаана.
- 6.1.2. Хэрэв Харилцагч нь данс болон бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдох аливаа өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг барагдуулж дуустал дансанд битүүмж тавьж, барагдуулж дууссан өдрөөс Гэрээг цуцалж, Гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцож, харилцагчийн дансыг хаана.
- 6.1.3. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Компани Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх эрхийг дуусгавар болгоно.
- 6.1.4. Харилцагч Үйлчилгээгээр дамжуулан бусдад хохирол учруулж болзошгүй буюу залилан, луйврын шинжтэй үйлдэл гаргасан эсхүл гарах нөхцөл бүрдүүлсэн, Компанид эсвэл гуравдагч этгээдэд хохирол учруулах үйлдлийг удаа дараа гаргасан тохиолдолд Компани Гэрээг дангаар цуцалж, данс болон бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаах эрхтэй.
- 6.1.5. Хуульд заасан бусад үндэслэл.

Долоо. Хариуцлага

- 7.1. Харилцагч залилан мэхлэх болон Гэрээгээр хүлээсэн бусад үүргийг зөрчих замаар Компанид хохирол учруулсан бол хохирлыг Харилцагчийн дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлнө.
- 7.2. Компанийн буруутай бус шалтгаанаар үйлчилгээ саатсан бол үүсэх үр дагаврыг Компани хүлээхгүй.
- 7.3. Талуудын аль нэг нь Гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг Гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.
- 7.4. Гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд Гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг нь бүрэн биелэгдэж дууссан хүртэл хугацаанд Гэрээний зохицуулалт нь Талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 7.5. Харилцагч нь өөрийн дансны дугаар, хүчинтэй хугацаа, нууц үг, болон бусад нууцлалын мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахгүй, алдахгүй байх, хэрэв дамжуулсан болон алдсаны улмаас хохирол учирвал түүнийг бүрэн хариуцна.
- 7.6. Харилцагч Америкийн Нэгдсэн Улсын харьяат иргэн бол W-9 маягтад заасан өөрийн болон дансны мэдээлэл, TIN эсхүл SSN эсхүл EIN дугаарыг АНУ-ын “Internal Revenue Service” (IRS)-д мэдээлэх зорилгоор Компанид мэдэгдэх, мэдэгдээгүйн улмаас үүсэх хариуцлагыг Харилцагч хариуцна.

Найм. Бусад зүйл

- 8.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, аль нэг талын хүсэлтээр Гэрээг цуцласнаар дуусгавар болно.
- 8.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 8.3. Гэрээний 8.2-т заасныг үл харгалзан зайнаас үйлчилгээ авах Харилцагчийн хувьд Компанийн онлайн үйлчилгээгээр дамжуулан, өөрийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг ашиглан Компаниас санал болгож буй Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, Үйлчилгээтэй холбоотой нэмэлт гэрээний төслийг зөвшөөрсөн үйлдэл хийснээр уг нэмэлт гэрээнд гарын үсэг зурсантай (Харилцагч нь хуулийн этгээд бол эрх бүхий этгээд нь гарын үсэг зурж, тамга эсхүл тэмдэг дарсантай адилд тооцно) ижил хүчин төгөлдөрт тооцно.

8.4. Харилцагч Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хэсэгчлэн болон дахин эсхүл шинээр авсан тохиолдолд тухайн авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд Гэрээний нөхцөл мөрдөгдөхөөр харилцан тохиролцов.

ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГАА

Харилцагчийн овог нэр	Регистрийн дугаар	Баталгаат гарын үсгийн маяг

*Харилцагч үйлчилгээтэй холбоотой баримтад гарын үсэг зурахдаа энэхүү маягтад батлуулсны дагуу зурна. Гэрээний нөхцлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон үйлчилгээний ерөнхий нөхцөл, Компанийн үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав (Харилцагч нь 18 нас хүрээгүй иргэн бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.):

Компанийг төлөөлж:

Брокер

Харилцагч:

Төлөөлөх этгээдийн нэр:

Албан тушаал:

Цахим хаяг:

Хавсралт 1

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Энэхүү Бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл нь (цаашид “БҮН” гэх) Харилцагчийн Компанитай байгуулсан Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-ний салшгүй хэсэг болно.
- 1.2. Энэхүү БҮН нь Компаниас харилцагчид санал болгож буй бүх төрлийн үйлчилгээний нөхцлүүдийн цогц болно.
- 1.3. Харилцагч БҮН, УШЕН-тэй бүрэн танилцсны үндсэн дээр өөрийн хүсч буй үйлчилгээг сонгох бөгөөд тус хүсэлт нь Гэрээний мөн салшгүй хэсэг болно.
- 1.4. Компанийн санал болгох үйлчилгээний зарим хэсэг нь төлбөртэй болно.
- 1.5. Харилцагч нь Компанийн онлайн үйлчилгээгээр дамжуулан сонгосон бүтээгдэхүүн үйлчилгээг цуцлах эсвэл шинээр үйлчилгээ нэмж авч болох бөгөөд энэ тохиолдолд талууд нэмэлт гэрээ байгуулахгүйгээр харилцан тохиролцсон бөгөөд Харилцагч нь өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан Компаниас онлайн үйлчилгээгээр дамжуулан хүргүүлж буй нөхцөлтэй танилцан, зөвшөөрөх үйлдэл хийснээр Талуудын хооронд нэмэлт гэрээ хийгдсэнд тооцно.
- 1.6. Харилцагч нь Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дараах сувгуудаар авах боломжтой. Үүнд:

№	Компаниас санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр	Өөрийн биеэр	Утсаар	Онлайнаар
1	ҮЦТХТ-н данс нээх	√		
	Кастодиан банкны харилцагчид данс нээх	√		
2	Үнэт цаасны захиалга	√	√	√
3	Мөнгө хүсэх өргөдөл	√	√	√
4	Дансны мэдээлэл, шинжилгээ	√	√	√
5	Нэмэлт үйлчилгээ			√

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭХ

- 2.1. ҮЦТХТ-д үнэт цаасны данс нээлгэх
 - 2.1.1. Харилцагчийн Компанид нээлгэсэн дансны дугаар нь байна.
 - 2.1.2. Харилцагч нь Компаниар дамжуулан ҮЦТХТ-д зөвхөн нэг үнэт цаасны данс нээлгэнэ.
 - 2.1.3. Компани нь данс нээхтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 2.1.3.1. Харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэн авч, ҮЦТХТ-д Харилцагчийг төлөөлөн үнэт цаасны данс нээлгэх;
 - 2.1.3.2. Ногдол ашиг, ногдол хувийн мөнгө гэх мэт ҮЦТХТ-өөр дамжин орж ирэх мөнгөн хөрөнгийн талаарх мэдээллийг харилцагчид хүргэх;
 - 2.1.3.3. Харилцагч мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан бол Компанийн бүртгэл болон ҮЦТХТ-н бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг авч засварлуулах;
 - 2.1.3.4. Харилцагчийн үнэт цаас шилжүүлэх хүсэлтийг хүлээн авч ҮЦТХТ-д хүргүүлэн шилжүүлгийг хийлгүүлэх;
 - 2.1.4. Компани нь данс нээхтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.1.4.1. Данс нээх болон харилцагчийг таниж мэдэхтэй холбоотой мэдээллийг Харилцагчаас гаргуулан авах;
 - 2.1.4.2. Харилцагчийн зах зээлийг урвуулан ашиглах болон зах зээлд хориглосон үйлдэл гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллагуудын шийдвэр эсвэл Компанийн шийдвэрээр дансыг идэвхигүй болгох;
 - 2.1.5. Харилцагч нь данс нээлгэхтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:

- 2.1.5.1. Данс нээхтэй холбоотой Компаниас шаардсан мэдээллийг үнэн зөв гарган өгөх;
 - 2.1.5.2. Үнэт цаасны төлбөр тооцоог хийхтэй холбоотой Төлбөр гүйцэтгэх банканд төлбөр тооцооны дундын дансыг нээлгэх;
 - 2.1.5.3. Дансыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглахгүй байх;
- 2.1.6. Харилцагч нь данс нээлгэхтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
- 2.1.6.1. Тогтоосон журмын дагуу данс нээлгэн үйлчлүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл авах;
 - 2.1.6.2. Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаар санал хүсэлт гаргах;
 - 2.1.6.3. Дансны үлдэгдэл, хуулга гэх мэт данстай холбоотой мэдээллийг гаргуулан авах.

2.2. Кастодиан банкны харилцагчид үнэт цаасны данс нээх

- 2.2.1. Харилцагч нь Кастодиан банк дээр хадгалагдах үнэт цаасыг худалдан авах, худалдах, шилжүүлэхтэй холбоотойгоор Компанид данс нээлгэнэ.
- 2.2.2. Компани нь Харилцагчийн Кастодиан банктай байгуулсан гэрээг үндэслэн Кастодиан банкны данс /client ID/ болон бенефициар өмчлөгч, номинал эзэмшигч аль нь болохыг бүртгэн авч дансыг нээнэ.
- 2.2.3. Компани нь данс нээхтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 2.2.3.1. Харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэн авч, баримтын бүрдүүлбэр хангасан Харилцагчийн дансыг нээх;
 - 2.2.4. Компани нь данс нээхтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.2.4.1. Компани нь зөвхөн дотоод журмын дагуу Харилцагчийн бүрдүүлсэн баримт бичигт үндэслэн данс нээх;
 - 2.2.4.2. Компанийн ҮШЕН-ийн дагуу шимтгэл хураамжийг Харилцагчаар төлүүлэх;
 - 2.2.5. Харилцагч нь данс нээлгэхтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 2.2.5.1. Данс нээлгэхтэй холбоотой Компаниас шаардсан мэдээлэл, материалыг үнэн зөв гарган өгөх;
 - 2.2.5.2. Кастодиан банкин дээрх дансны дугаар, эзэмшлийн хэлбэр зэрэг мэдээллийг үнэн зөв бүрдүүлэн өгөх;
 - 2.2.5.3. Компанийн ҮШЕН-д заасны дагуу холбогдох шимтгэл, хураамжийг үл маргаж журмаар саадгүй төлөх;
 - 2.2.6. Харилцагч нь данс нээлгэхтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.2.6.1. Компанийн үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээнээс сонгон үйлчлүүлэх;
 - 2.2.6.2. Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаар санал хүсэлт гаргах.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА

- 3.1. Харилцагч нь үнэт цаас худалдан авахын тулд Компанийн гэрээтэй Төлбөр гүйцэтгэх банкны үнэт цаасны төлбөр тооцооны хамтран эзэмших дундын дансанд эсвэл Компаниас зөвшөөрсөн тохиолдолд Компанийн үнэт цаасны төлбөр тооцооны дансанд хангалттай хэмжээний мөнгө байршуулсан байна. Харилцагч нь Кастодиан банкны харилцагч бөгөөд номинал эзэмшигч бол Компани нь Кастодиан банкнаас үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн лавлагаа авсаны үндсэн дээр захиалгыг хүлээн авна.
- 3.2. Харилцагчийн дансны боломжит үлдэгдэл нь хүрэлцэхгүй тохиолдолд Компани нь Харилцагчаас захиалга хүлээн авахгүй.
- 3.3. Харилцагчийн захиалгыг Компани нь зөвхөн Монголын хөрөнгийн биржийн зөвшөөрөгдсөн арилжааны цагаар биржийн систем руу дамжуулна.
- 3.4. Харилцагч нь Компаниас санал болгож буй үйлчилгээний хэлбэрүүдээс сонгон үнэт цаас худалдан авах, худалдах захиалга өгөх ба захиалгын хүчин төгөлдөр байх хугацаа нь захиалгын хэлбэр болон Монголын хөрөнгийн биржийн дүрэм, журамд зааснаар тогтоогдоно.
- 3.5. Харилцагч нь захиалга өгөхдөө зах зээлийн болон нөхцөлт захиалга өгч болох ба захиалгын үргэлжлэх хугацаа, нэгжийн үнэ, тоо ширхэгийг нарийвчлан тусгана.
- 3.6. Харилцагч зах зээлийн захиалга өгөхөд захиалга үргэлжлэх хугацааг сонгохгүй бөгөөд Монголын хөрөнгийн биржийн захиалгын санд байгаа худалдах, худалдан авах боломжтой эсхүл ямар нэг хязгаарлалтгүй байгаа хувьцааг сонгоно.
- 3.7. Харилцагч нөхцөлт захиалга өгөхдөө тухайн худалдаж авах үнэт цаас, түүний тоо ширхэг, үнэ, захиалга үргэлжлэх хугацааг тодорхой зааж захиална.
- 3.8. Харилцагч нь захиалгыг зөвхөн биелэгдэхээс өмнө буюу арилжаа хийгдэхээс өмнө цуцлах, тухайн захиалгад өөрчлөлт оруулах боломжтой байна.
- 3.9. Харилцагчийн үнэт цаас худалдан авах, худалдах захиалгын ханш нь тухайн үнэт цаасны хаалгын ханшнаас эрх бүхий байгууллагын тогтоосон хувиас хэтэрсэн тохиолдолд Компани тус захиалгыг хүлээн авахгүй.
- 3.10. Холбогдох хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг зөрсөн захиалгыг Харилцагчаас Компани хүлээн авахгүй бөгөөд хэрэв хүлээн авч гүйцэтгэсэн тохиолдолд тухайн захиалгын биелэлтээс гарах үр дагаварыг зөвхөн Харилцагч бие даан хариуцна.
- 3.11. Харилцагч нь захиалгаа өөрийн биеэр, утсаар болон онлайнгаар өгч болно.
- 3.12. Харилцагч өөрийн биеэр захиалга өгөх тохиолдолд иргэний (хуулийн этгээдийн хувьд төлөөлөх эрх бүхий этгээдийн) хүчин төгөлдөр баримт бичигтэйгээ Компанид ирж, захиалгын баримтад Компанид бүртгүүлсэн баталгаат гарын үсгийг зурж захиалгаа өгнө
- 3.13. Харилцагч утсаар захиалга өгөх
 - 3.13.1. Харилцагч нь утсаар захиалга өгөхдөө Компанид хандан тус үйлчилгээнд бүртгүүлж, бататгах нууц асуулт, нууц хариултыг Компанид бүртгүүлэх бөгөөд дараах байдлаар захиалгаа өгнө. Үүнд:
 - 3.13.1.1 Захиалга өгөх этгээд мөн эсэхийг баталгаажуулах нууц асуултанд үнэн зөв хариулсан байна. Шаардлагатай тохиолдолд Компанийн ажилтан нь харилцагчаас нэмэлт мэдээллийг тодруулсны үндсэн дээр захиалгыг хүлээн авна.
 - 3.13.1.2 Харилцагч нууц асуултанд 3 удаа буруу хариулбал утсаар захиалгыг хүлээн авахгүй.
 - 3.13.1.3 Утсаар захиалга өгсөн Харилцагч нь ажлын 3 хоногийн дотор захиалгын гэрээн дээр өөрийн биеэр ирж гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй ба уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд дараагийн 3 сарын хугацаанд тухайн Харилцагчаас дахин утсаар захиалга хүлээн авахгүй.
 - 3.13.1.4 Харилцагч нь Компанид бүртгэлтэй дугаараас өөр дугаараар холбогдсон бол данстай холбоотой мэдээлэл өгөх, захиалга авахаас татгалзана
- 3.14. Харилцагч онлайнгаар захиалга өгөх
 - 3.14.1. Харилцагч нь онлайнгаар захиалга өгөхдөө Компанид хандан Компанийн онлайн үйлчилгээнд бүртгүүлж, интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан, www.tdbcapiatal.mn болон www.ebank.mn цахим хуудсуудаар дамжуулан захиалгаа өгнө.
 - 3.14.2 Кастодиан банкны харилцагч нь онлайнгаар захиалга өгөхдөө кастодиан банк гэсэн нэмэлт тэмдэглэгээг сонгож захиалгаа оруулна
- 3.15. Компани нь үнэт цаасны захиалгатай холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 3.15.1. Харилцагчийн өгсөн захиалгыг нэн даруй бүртгэж арилжаанд оруулах;
 - 3.15.2. Захиалгын биелэлттэй холбоотой мэдээллийг эргэн мэдэгдэх;
 - 3.15.3. Онлайн үйлчилгээний эрх авсан харилцагчийн нэвтрэх нэр, нууц үгийг харилцагчийн бүртгэлтэй цахим хаягаар илгээх;
 - 3.15.4. Онлайнгаар өгсөн захиалгыг хэвлэх боломжтойгоор Харилцагчид харуулах;
- 3.16. Компани нь үнэт цаасны захиалгын үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 3.16.1. Захиалгын баримтын мэдээлэл нь харилцагчийн буруутай үйлдлээс үүдэн алдаатай, буруу бичигдсэнээс үүсэх хохирлыг компани хариуцахгүй;
 - 3.16.2. Үнэт цаасны ханшид зохиомлоор нөлөөлөх, зах зээлийн урвуулан ашиглаж болзошгүй захиалгыг хүлээн авахаас татгалзах;
 - 3.16.3. Харилцагч нь Компанийн хүлээн авсан захиалгад өөрчлөлт оруулах, цуцлах боломжтой хэдий ч хэрэв тухайн үндсэн захиалга нь Монголын хөрөнгийн бирж дээр биелэгдсэн тохиолдолд харилцагчийн захиалга цуцлах, захиалгад өөрчлөлт оруулах хүсэлтийг Компани хүлээн авахаас татгалзах;
 - 3.16.4. Харилцагчийн дансны боломжит үлдэгдэл нь хүрэлцэхгүй тохиолдолд Компани нь захиалгыг хүлээн авахгүй байх;
 - 3.16.5. Харилцагчийн үнэт цаасны арилжаанаас Компанийн ҮШЕН-д заасны дагуу холбогдох шимтгэл, хураамжийг төлөхийг Харилцагчаас шаардах эсвэл шууд суутган авах
 - 3.16.6. Харилцагчийн онлайнгаар нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан өгсөн захиалгыг харилцагчийн Компанид өгсөн гарын үсгийн маягтын дагуу баталгаажуулсан захиалгын нэгэн адил хүчин төгөлдөр гэж үзэх;

- 3.16.7. Харилцагч болон Компанийг эрсдэлээс хамгаалан, нэвтрэх нэр болон нууц үгийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд харилцагчийн эрхийг автоматаар идэвхигүй болгох;
- 3.16.8. Шаардлагатай тохиолдолд онлайн захиалгын үйлчилгээг зогсоох;
- 3.17. Харилцагч нь үнэт цаасны захиалгатай холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
- 3.17.1. Үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө төлбөр тооцооны дансанд урьдчилан байршуулах;
- 3.17.2. Нэвтрэх нууц үгээ мартсан тохиолдолд Компанид бүртгүүлсэн цахим хаягаар нууц үгээ шинээр үүсгэн авах;
- 3.17.3. Хэрэв нууц үгээ 3 удаа буруу хийж, эрхээ хаалгасан бол Компанийн санал болгосон боломжит хэлбэрээр компанид хандаж нэвтрэх эрхээ идэвхигүйлэх;
- 3.17.4. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам зөрчсөн захиалга өгөхгүй байх, өгсөнөөс үүдэн гарах хариуцлагыг бие даан хүлээх;
- 3.17.5. Онлайнгаар үнэт цаас худалдах, худалдан авах захиалгаа үнэн зөв бөглөх бөгөөд тус захиалгын үнэн, зөв байдлыг Харилцагч дангаар хариуцах;
- 3.17.6. Харилцагч нь онлайнгаар үнэт цаасны нэр, захиалгын төрөл, нөхцөл, хугацаа, тоо ширхэг, үнэ гэх мэт захиалгатай холбоотой мэдээллүүдийг алдаатай оруулсан бол нэн даруй захиалга өөрчлөх хэлбэрээр засварыг оруулах ба засвар хийгдэхээс өмнө үндсэн захиалга биелэгдсэн байж болохыг анхаарах;
- 3.17.7. Онлайнгаар нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх бөгөөд нууцлалын бүрэн бүтэн байдлыг бие даан хариуцах;
- 3.17.8. Онлайнгаар захиалга өгөхдөө өөрийн интернетийн шугам, ашиглаж буй компьютер, гар утас, таблетийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- 3.17.9. Онлайнгаар өгсөн захиалгын биелэлтийг тухай бүр хуулгатай тулгаж шалгах;
- 3.17.10. Харилцагч өөрийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр Компанид мэдэгдэн өөрчлөлтийг тэмдэглүүлэх;
- 3.17.11. Гуравдагч этгээдэд онлайнгаар дансаа захиран зарцуулах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн тохиолдолд Компанид энэ тухай хандаж, албан ёсны итгэмжлэлээр шилжүүлэх;
- 3.17.12. Онлайн захиалгын үйлчилгээг ашиглаж дууссан даруйдаа програмаас бүрэн гарч байх, энэ үүргийг дагаагүйгээс болж үүдэн гарах хохирлыг хариуцах;
- 3.18. Харилцагч нь үнэт цаасны захиалгын үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:
- 3.18.1. Харилцагч нь захиалгыг өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан өгч болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн хувьд хүчин төгөлдөр итгэмжлэлийг Компанид урьдчилан ирүүлэх;
- 3.18.2. Захиалга өгөхдөө компанийн үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээнээс сонгон үйлчлүүлэх;
- 3.18.3. Онлайн үйлчилгээний хугацааг сунгах хүсэлтийг онлайнгаар илгээх;
- 3.18.4. Дансны шинжилгээ, график шинжилгээний мэдээлэл авах;
- 3.18.5. Бичгээр гаргасан хүсэлтээр онлайн үйлчилгээний эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах (Энэ тохиолдолд өмнө нь төлсөн хураамжийг Компани буцаан олгохгүй);
- 3.18.6. Онлайн захиалгын үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг Компанид гаргах;
- 3.18.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг компаниас шаардах;
- 3.18.8. Захиалгын гэрээ, хуульыг компаниас гаргуулан авах;
- 3.19. Үнэт цаасны захиалгын үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага
- 3.19.1. Онлайн үйлчилгээ авсан харилцагчийн интернэт үйлчилгээ нийлүүлэгч байгууллага болон үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагч www.tdbcapiatal.mn болон www.ebank.mn цахим хуудсуудад холбогдоход сүлжээний саатал, шилжүүлгийг хүлээн авах банкны үйл ажиллагааны доголдол, эсвэл харилцагчийн холбогдож буй компьютер, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үүссэн аливаа хохирлыг Компани хариуцахгүй.
- 3.19.2. Онлайн захиалгын үйлчилгээнд холбогдоход нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байх бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг Компани хариуцахгүй.

ДӨРӨВ. МӨНГӨ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ

- 4.1. Харилцагч нь Арилжааны төлбөр тооцоо ХХК (цаашид “АТТ” гэх), ҮЦТХТ, Төлбөр гүйцэтгэх банк болон Кастодиан банк дахь мөнгөн хөрөнгийн данснаасаа зарлага гаргах тохиолдолд Компаниаар дамжуулан мөнгө хүсэх өргөдлийг өгнө.
- 4.2. Мөнгө хүсэх өргөдлөөр зарлага гаргахдаа зөвхөн данс эзэмшигчийн нэр дээрх арилжааны банкны дансруу шилжүүлэг хийгдэнэ.
- 4.3. Мөнгө хүсэх өргөдлөөр өөр төрлийн валютын дансруу шилжүүлэг хийгдэх бол тухайн үеийн харилцаж буй банкны зарласан валютын ханшаар тооцно.
- 4.4. Кастодиан банкны харилцагч нь номинал эзэмшигчийн данснаас мөнгө хүсэх өргөдлөөр мөнгөн хөрөнгөө шилжүүлэн авах бол Кастодиан банкнаас харилцагчийн боломжит үлдэгдлийг лавласны үндсэн дээр хүсэлтийг хүлээн авна.
- 4.5. Харилцагч нь мөнгө хүсэх өргөдлөө өөрийн биеэр болон онлайнгаар өгч болно.
- 4.6. Харилцагч мөнгө хүсэх өргөдлөө өөрийн биеэр өгөх
- 4.6.1. Харилцагч мөнгө хүсэх өргөдлөө өөрийн биеэр (хуулийн этгээдийн хувьд төлөөлөх эрх бүхий этгээд өөрийн биеэр) өгөх тохиолдолд иргэний хүчин төгөлдөр баримт бичигтэйгээ Компани дээр ирж, компанид бүртгүүлсэн баталгаат гарын үсгийг зурж хүсэлтээ өгнө.
- 4.6.2. Харилцагчийн биеэр хүлээн авч баталгаажсан мөнгө хүсэх өргөдлийн хүчинтэй хугацаа нь ажлын 3 хоног байна.
- 4.7. Харилцагч мөнгө хүсэх өргөдлөө онлайнгаар өгөх
- 4.7.1. Харилцагч мөнгө хүсэх өргөдлөө онлайнгаар өгөх тохиолдолд Компанид хандан Компанийн онлайн үйлчилгээнд бүртгүүлж, интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан, www.tdbcapiatal.mn болон www.ebank.mn цахим хуудсуудаар дамжуулан хүсэлтээ өгнө.
- 4.7.2. Харилцагч онлайн үйлчилгээг ашиглан мөнгө хүсэх өргөдлийг 7 хоногийн 24 цагийн хүссэн үедээ илгээж болох бөгөөд Компани нь ажлын өдрүүдэд, ажлын цагаар хүсэлтийг хүлээн авч Төлбөр гүйцэтгэх банкинд хүргүүлнэ.
- 4.8. Компани нь мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.8.1. АТТ, ҮЦТХТ, Кастодиан банк болон Төлбөр гүйцэтгэх банк дээрх үлдэгдлийг тус байгууллагуудаас мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг лавласны үндсэн дээр мөнгө хүсэх өргөдлийг хүлээн авах;
- 4.8.2. Онлайн үйлчилгээг ашиглан мөнгө хүсэх өргөдөл илгээх заавар, зөвлөмж өгөх;
- 4.8.3. Мөнгө хүсэх өргөдлөөр авч болох боломжит үлдэгдлийн талаар мэдээлэл өгөх;
- 4.9. Компани нь мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
- 4.9.1. Харилцагчийн дансны боломжит үлдэгдэл нь хүрэлцэхгүй тохиолдолд Компани нь мөнгө хүсэх өргөдлийг хүлээн авахаас татгалзах;
- 4.9.2. Харилцагчийн онлайнгаар илгээсэн мөнгө хүсэх өргөдөл нь алдаатай эсвэл боломжит үлдэгдэл хүрэлцэхгүй бол хүсэлтийг цуцлах;
- 4.10. Харилцагч нь мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.10.1. Онлайнгаар мөнгө хүсэх өргөдлөө үнэн зөв бөглөж илгээх;
- 4.10.2. Онлайнгаар нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх бөгөөд нууцлалын бүрэн бүтэн байдлыг бие даан хариуцах;
- 4.10.3. Онлайнгаар мөнгө хүсэх өргөдөл илгээхдээ өөрийн интернетийн шугам, ашиглаж буй компьютер, гар утас, таблетийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- 4.11. Харилцагч нь мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:
- 4.11.1. Онлайнгаар өгсөн мөнгө хүсэх өргөдлөө Компани хүлээн авахаас өмнө цуцлах;
- 4.11.2. Онлайнгаар нэвтрэх нууц үгээ мартсан тохиолдолд Компанид бүртгүүлсэн цахим хаягаар нууц үг үүсгэн авах;
- 4.11.3. Хэрэв нууц үгээ 3 удаа буруу хийж эрхээ хаалгасан бол Компаниас санал болгосон боломжит хэлбэрээр компанид хандаж нэвтрэх эрхээ идэвхигүйлэх;
- 4.11.4. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, орлого, зарлагын мэдээллийг Компаниас гаргуулан авах;
- 4.12. Мөнгө хүсэх өргөдөлтэй холбоотой нэмэлт хариуцлага

- 4.12.1. Харилцагч нь мөнгө хүсэх өргөдлөөр мөнгөн хөрөнгөө бэлэн бусаар шилжүүлэн авч авахдаа шилжин орж буй дансны дугаар, мэдээллийг үнэн зөв өгөх бөгөөд данс нэр зөрсөн, дансны дугаар буруу байснаас үүдэн гарах хохирлыг Харилцагч бие даан хариуцна.
- 4.12.2. Онлайн мөнгө хүсэх өргөдлийн үйлчилгээнд холбогдоход нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байх бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг Компани хариуцахгүй.

ТАВ. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ, ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРТГҮҮЛЭХ

- 5.1. Харилцагч нь үнэт цаасны данстай холбоотой мэдээллээ өөрийн биеэр, утсаар болон онлайнгаар авч болно.
- 5.2. Харилцагч нь Компанийн үйлчилгээнд өөрийн биеэр болон онлайнгаар бүртгүүлж болно.
- 5.3. Харилцагч өөрийн биеэр ирж мэдээлэл авах
- 5.3.1. Харилцагч нь өөрийн биеэр ирж үнэт цаасны үлдэгдэл, дансны хуулга, тодорхойлолт гэх мэт данстай холбоотой үйлчилгээг авах тохиолдолд иргэний (хуулийн этгээдийн хувьд төлөөлөх эрх бүхий этгээдийн) хүчин төгөлдөр баримт бичигтэйгээ ирж үйлчилгээ авна.
- 5.4. Харилцагч утсаар мэдээлэл авах
- 5.4.1. Харилцагч нь утсаар дансны мэдээлэл авахдаа Компанид хандан тус үйлчилгээнд бүртгүүлж, өөрийгөө (хуулийн этгээдийн хувьд төлөөлөх эрх бүхий этгээд) багатгах нууц асуулт, нууц хариултыг Компанид бүртгүүлэх бөгөөд дараах байдлаар мэдээлэл авна. Үүнд:
- 5.4.1.1. Өөрийгөө баталгаажуулах нууц асуултанд үнэн зөв хариулсан байна. Шаардлагатай тохиолдолд Компанийн ажилтан нь харилцагчаас нэмэлт мэдээллийг тодруулсаны үндсэн дээр мэдээллийг хүргэнэ.
- 5.4.1.2. Харилцагч нууц асуултанд 3 удаа буруу хариулбал Компанийн ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзана.
- 5.5. Харилцагч онлайнгаар мэдээлэл, үйлчилгээ авах
- 5.5.1. Харилцагч нь онлайнгаар мэдээлэл авахдаа Компанид хандан Компанийн онлайн үйлчилгээний эрхээ нээлгэсэн байх бөгөөд интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан, www.tdbcapital.mn болон www.ebank.mn цахим хуудсуудаар дамжуулан Компанийн үйлчилгээг дараах байдлаар авна. Үүнд:
- 5.5.1.1. Компани нь харилцагчийн нэвтрэх нэр, нууц үгийг харилцагчийн бүртгэлтэй цахим хаягаар илгээнэ.
- 5.5.1.2. Харилцагч нь онлайнгаар өөрийн үнэт цаасны болон төлбөр тооцооны дундын дансны үлдэгдэл, хуулга харах, дансны шинжилгээ, үнэт цаасны ханшийн график шинжилгээ харах, үнэт цаасны ханшны мэдээлэл харах боломжтой байна.
- 5.5.1.3. Харилцагч нь онлайн захиалга, мөнгө хүсэх өргөдөл гэх мэт бусад компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах хүсэлтээ энэхүү үйлчилгээг ашиглан гаргаж болно.
- 5.5.1.4. Харилцагч нь нууц үгээ мартсан тохиолдолд “нууц үгээ мартсан” гэсэн хэсгийг сонгож компанид бүртгүүлсэн цахим хаягаар нууц үг үүсгэн авах боломжтой.
- 5.5.1.5. Хэрэв нууц үгээ 3 удаа буруу хийж эрхээ хаалгасан бол Компаниас санал болгосон боломжит хэлбэрээр компанид хандаж нэвтрэх эрхээ сэргээлгэнэ.
- 5.5.1.6. Харилцагч нь энэхүү үйлчилгээг ашиглан онлайн үйлчилгээг цуцлах боломжтой.
- 5.6. Компани нь дансны мэдээлэлтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.6.1. Харилцагчийн хүсэлтийн дагуу дансны мэдээллийг гаргаж өгөх;
- 5.6.2. Харилцагчийн илгээсэн хүсэлтийн дагуу онлайн захиалга, мөнгө хүсэх өргөдөл болон бусад үйлчилгээнд бүртгэх;
- 5.6.3. Үнэт цаасны ханшийг мэдээллийг тогтмол шинэчлэн хүргэх;
- 5.6.4. Харилцагчийн хүсэлтийн дагуу онлайн үйлчилгээг цуцлах.
- 5.7. Компани нь дансны мэдээлэлтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:
- 5.7.1. Харилцагч болон Компанийг эрсдэлээс хамгаалан онлайнгаар нэвтрэх нэр болон нууц үгийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд Харилцагчийн эрхийг автоматаар идэвхигүй болгох;
- 5.7.2. Онлайн үйлчилгээгээр ирүүлсэн хүсэлтийн талаар Харилцагч талаас ямар нэгэн хариу ирүүлэхгүй хуанлын 30-с дээш хоног өнгөрсөн тохиолдолд Компани хүсэлтийг цуцлах.
- 5.8. Харилцагч нь дансны мэдээлэлтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.8.1. Онлайн үйлчилгээ авсан бол цахим хаяг өөрчлөгдсөн тухай бүр Компанид мэдэгдэн өөрчлөлтийг бүртгүүлэх;
- 5.8.2. Онлайнгаар нэвтрэх нэр, нууц үгийг бусад дамжуулахгүй байх бөгөөд нууцлалын бүрэн бүтэн байдлыг бие даан хариуцах;
- 5.8.3. Онлайн үйлчилгээгээр хандаж буй интернетийн шугам, ашиглаж буй компьютер, гар утас, таблетийн нууцлалын аюулгүй байдлыг хангах;
- 5.8.4. Компани нь харилцагчийн онлайн үйлчилгээний нэвтрэх нэр, нууц үгсийн талаарх мэдээллийг Харилцагчаас авахаар шаардахгүй тул Компанитай ижил нэр, цахим хаягнаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх үүрэгтэй ба үүнээс үүдэн гарах хохирлыг бүрэн хариуцна.
- 5.9. Харилцагч нь дансны мэдээлэлтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:
- 5.9.1. Шаардлагатай үедээ Компанид хандан дансны үлдэгдэл, хуулга, тодорхойлолт болон бусад өөрийн данстай холбоотой мэдээллийг гаргуулан авах;
- 5.9.2. Дансны шинжилгээ, график шинжилгээ, үнэт цаасны ханшийн мэдээлэл авах;
- 5.9.3. Бичгээр гаргасан хүсэлтээр үйлчилгээний эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах;
- 5.9.4. Онлайн үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг Компанид гаргах;
- 5.10. Дансны мэдээлэлтэй холбоотой нэмэлт хариуцлага
- 5.10.1. Харилцагч онлайн үйлчилгээгээр холбогдоход интернэт үйлчилгээ нийлүүлэгч байгууллага болон үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагч www.tdbcapital.mn болон www.ebank.mn цахим хуудсуудад холбогдоход сүлжээний саатал, эсвэл харилцагчийн холбогдож буй компьютер, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үүссэн аливаа хохирлыг Компани хариуцахгүй.
- 5.10.2. Онлайнгаар үйлчилгээнд холбогдоход нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байх бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг Компани хариуцахгүй.